

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2020 оны 6 дугаар сарын 2-ны өдөр

Дугаар А/280

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 дугаар бүлгийн 3.2.9 заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжил болон сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх журам-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Энэхүү журмыг 2020-2021 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлж ажиллахыг өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэгийн эрхлэгч нарт даалгасугай.
3. Тушаалыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч ажиллахыг холбогдох албан тушаалтанд үүрэг болгосугай.
 - 3.1. Журмын хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Сургуулийн өмнөх боловсролын газар /Ж.Мягмар/, нийслэлийн Боловсролын газар, аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын дарга нарт;
 - 3.2. Журмыг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж боловсруулж, цахим сургалтыг 2020 оны 3 дугаар улиралд багтаан зохион байгуулахыг Сургуулийн өмнөх боловсролын газар /Ж.Мягмар/, Боловсролын хүрээлэн /П.Лхагвасүрэн/, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт /Ж.Болормаа/-д;
 - 3.3. Сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх үнэлгээг 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлэх бэлтгэлийг хангаж, даалгаврын сан бүрдүүлэх, үнэлгээний үр дүнг боловсролын салбарын мэдээллийн системд байршуулах, шинжилгээ хийх программ хангамжийн хөгжүүлэлтийн шийдлийн саналыг боловсруулж, 2020 оны 8 дугаар сард багтаан танилцуулахыг Боловсролын үнэлгээний төв /Ж.Ган-Эрдэнэ/-д;
 - 3.4. Журмыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг жил бүр улсын төсөвт тусгаж ажиллахыг Санхүү, эдийн засгийн газар /С.Нансалмаа/, Боловсролын үнэлгээний төв /Ж.Ган-Эрдэнэ/, нийслэлийн Боловсролын газар, аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын дарга нарт.
4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын "Хөтөлбөр батлах тухай" 2019 оны А/494 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.
5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэнд даалгасугай.

САЙД Ё.БААТАРБИЛЭГ